Аж ахуйн материал	224,460.8	166,152.2	(58,308.6)
Сэлбэг хэрэгсэл		696.0	696.0
Түлш, шатах тослох материал	8,216.1	1,100.0	(7,116.1)
Хүнсний материал	5,958.2	737.9	(5,220.3)
Барилгын засварын материал	7,327.0	2,907.0	(4,420.0)
Бусад хангамжийн материал	100,464.9	114,437.9	13,973.0
Дүн	412,646.6	380,391.1	(32,255.5)

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсөвт байгууллагуудын дүнгээр 381711.7 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 413967.2 мянган төгрөгийн бараа материал хасагдсан ба аж ахуйн материал 58308.6 мянган төгрөгөөр хасагдсан нь бараа материалын дүн буурахад голлох нөлөө үзүүлжээ.

Хүснэгт 5. Байгууллагын бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн			БҮГД	Хасагдсан		БҮГД	Эцсийн үлдэгдэл
		Төсвийн хөрөнгөөр	Хандиваар	Бусад		Худалдсан, зарцуулсан	Бусад		
ИТХурал	2,195.1	6,735.9		323.4	7,059.3	7,401.5		7,401.5	1,852.9
ЗДТГазар	128,375.2	59,130.6	347.4	45,645.2	105,123.2	103,587.3		103,587.3	129,911.1
Сургууль	127,961.3	96,850.4		994.4	97,844.8	85,960.2	26,241.8	112,202.0	113,604.1
Цэцэрлэг	83,400.5	36,264.0	140.0		36,404.0	65,931.8		65,931.8	53,872.7
Соёл	12,896.0	2,963.8			2,963.8	2,568.0	430.8	2,998.8	12,861.0
ЭМТөв	23,081.4	70,395.7	16,369.2		86,764.9	67,103.9		67,103.9	42,742.4
Бага сургууль	17,577.5	29,575.2		70.0	29,645.2	24,998.7	8,163.6	33,162.3	14,060.4
Бага цэцэрлэг	17,159.6	15,766.5		140.0	15,906.5	12,324.5	9,255.1	21,579.6	11,486.5
ДҮН	412,646.6	317,682.1	16,856.6	47,173.0	381,711.7	369,875.9	44,091.3	413,967.2	380,391.1

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 18017341.4 мянга, эцсийн үлдэгдэл 18122404.9 мянган төгрөг болж, 105063.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	15,890,342.0	15,916,079.9	25,737.8
Тээврийн хэрэгсэл	325,530.5	325,530.5	-
Машин тоног төхөөрөмж	600,228.9	652,873.5	52,644.6
Тавилга эд хогшил	350,475.4	363,104.6	12,629.3
Түүх, соёлын дурсгалт зүйлс	7,000.0	7,000.0	-
Номын фонд	55,604.8	58,776.7	3,171.9
Бусад үндсэн хөрөнгө	100,661.5	111,661.5	11,000.0
Дуусаагүй барилга байгууламж	506,816.0	506,816.0	-
Программ хангамж	19,094.2	18,974.2	(120.0)
Бусад биет бус хөрөнгө	161,588.0	161,588.0	-
Дүн	18,017,341.4	18,122,404.9	105,063.5

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 54631.6 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 1310.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар авч, 41478.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг

бусад байгууллагуудаас шилжүүлэн авч, 5 байгууллага тус бүр нь 200.0 мянган төгрөгийн үнэ бүхий архивын программыг акталж, цэцэрлэг 2647.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлжээ.

Хүснэгт №7. Байгууллагын үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн				БҮГД	Хасагдсан		БҮГД	Эцсийн үлдэгдэл
			Төсвийн хөрөнгөөр	Хандиваар	Шилжүүлэн авсан	Бусад		Акталсан	Шилжүүлсэн		
1	ИТХурал	17,419.0	1,700.0	-	-	-	1,700.0	200.0	-	200.0	18,919.0
2	ЗДТГазар	5,321,996.6	5,555.8	-	36,230.3	-	41,786.1	-	-	-	5,363,782.7
3	Сургууль	7,105,367.0	14,355.4	-	-	4,249.1	18,604.5	200.0	-	200.0	7,123,771.4
4	Цэцэрлэг	1,262,347.5	11,935.2	-	5,248.5	-	17,183.7	-	-	-	1,279,531.2
5	Соёл	2,019,706.1	330.0	-	-	-	330.0	200.0	2,647.7	2,847.7	2,017,188.4
6	ЭМТөв	2,030,466.0	14,144.7	1,310.0	-	-	15,454.7	200.0	-	200.0	2,045,720.7
7	Бага сургууль	258,218.2	6,610.5	-	-	1,793.2	8,403.7	-	-	-	266,621.9
8	Бага цэцэрлэг	1,821.0	-	-	-	5,248.5	5,248.5	200.0	-	200.0	6,869.5
ДҮН		18,017,341.4	54,631.6	1,310.0	41,478.8	11,290.7	108,711.2	1,000.0	2,647.7	3,647.7	18,122,404.9

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрт урт хугацаат зээл байхгүй, богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 4176.6 мянга, эцсийн үлдэгдэл 25165.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 20988.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	4176.6	25165.3	20988.7
Ажилчидтай холбогдсон өглөг	1425	1299.1	-125.9
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2751.6	23866.2	21114.6
Урт хугацаат өр төлбөр дүн	0	0	0
Дүн	4176.6	25165.3	20988.7

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өглөгийн 94.8 хувийг бараа үйлчилгээний зардлын өглөг, 5.2 хувийг ажиллагсадтай холбоотой өглөг эзэлж байгаагаас бараа үйлчилгээний зардлын өглөгийн 87.8 хувь буюу 22102.5 мянган төгрөгийн өглөг нь сургуулийн өглөг эзэлж байна.

Хүснэгт №9. Байгууллагын өглөг /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:	
			Ажиллагсадтай холбоотой	Бараа үйлчилгээний зардлын өглөг
ЗДТГ	2,177.6	2,113.5	1,046.9	1,066.6
Сургууль	-	22,102.5	-	22,102.5
Соёлын төв	292.8	87.5	87.5	-
Цэцэрлэг	44.1	192.6	164.6	28.0
Бага сургууль	942.5	668.7	-	668.7
ЭМТ	719.6	0.5	-	0.5
ДҮН	4,176.7	25,165.3	1,299.1	23,866.2

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 15658780.9 мянга, эцсийн үлдэгдэл 14911057.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 747723.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Хүснэгт №10. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,132,340.9	2,132,340.9	-	14.3
Хуримтлагдсан үр дүн	10,346,587.7	9,753,833.2	(592,754.5)	65.4
Өмнөх үеийн үр дүн	10,769,328.9	10,501,556.8	(267,772.1)	
Тайлант үеийн үр дүн	(422,741.2)	(747,723.6)	(324,982.4)	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,179,852.3	3,024,883.3	(154,969.0)	20.3
Дүн	15,658,780.9	14,911,057.4	(747,723.5)	100

Эх сурвалж: .Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.10 Орлогын данс

Бууцагаан сумын ИТХ-ын 2019.12.16-ний өдрийн хуралдааны 12 дугаар тогтоолоор Бууцагаан сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 5000.0 мянга, аймгийн төсөвт 132600.0 мянга, нийт 137600.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр төлөвлөгөөг 110.1 хувиар биелүүлснээс улсын төсөвт төвлөрөх татварын орлогыг 749.5 мянга, аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 13094.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №11. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А. Улсын төсөв	5,000.0	5,749.5	749.5	115.0
1. ААНБ-ын орлогын татвар	1,000.0	3,318.1	2,318.1	331.8
2. Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,800.0	541.9	(2,258.1)	19.4
3. Агаарын бохирдол /авто/	1,200.0	1,889.5	689.5	157.5
В. Аймгийн төсөв /712/	132,600.0	145,694.0	13,094.0	109.9
1. ЦТХА орлого /Суутган -1/	115,000.0	126,903.4	11,903.4	110.4
2. АТӨЯХ-ийн татвар	13,700.0	17,006.9	3,306.9	124.1
3. ҮХЭХ-ийн татвар	1,500.0	1,387.9	(112.1)	92.5
4. Газрын төлбөр	2,400.0	395.8	(2,004.2)	16.5
Нийт дүн	137,600.0	151,443.5	13,843.5	110.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Сумын ИТХ-ын 2019.12.16-ний өдрийн хуралдааны 12 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 79600.0 мянга, хүү торгуулийн орлогыг 15000.0 мянга, нийт 94600.0 мянган төгрөгөөр баталсныг сумын ИТХ-ын 2020.09.25-ний өдрийн хуралдааны 06 дугаар тогтоолоор сумын 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийг 12000.0 мянган төгрөгөөр төлөвлөснийг хасаж тодотгон, хүү торгуулийн орлогыг 17000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 32000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 99600.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №12. Сумын төсөвт төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	67,600	95,242	27,642	140.9
1.1.ИОТХ	7,500.00	35,649.00	28,149.00	475.32
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	44,500.00	42,860.80	-1,639.20	96.32
1.3. ҮХЭХ борлуулсны татвар	0.00	1,688.50	1,688.50	#DIV/0!
1.3. Бууны татвар	2,000.00	1,770.00	-230.00	88.50
1.4.Улсын тэмдэгтийн хураамж	3,000.00	3,243.50	243.50	108.12
1.5.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	8,000.00	9083.9	1,083.90	113.55
1.6.Ургамал ашигласны төлбөр			0.00	0.00
1.7.Түгээмэл тархацтай АМНАТ	1,000.00	635	-365.00	63.50
1.8.Агнуурын нөөц ашигласны			0.00	#DIV/0!
1.9.Газрын төлбөр	1600	311.7	-1,288.30	19.48

2.Татварын бус орлого	32,000	37,217	5,217	116.30
2.1.Хүү торгуулийн орлого	32000	37217.1	5,217.10	116.30
Нийт дүн	99,600.00	132,459.50	32,859.50	132.99

Эх сурвалж: Дансны хуулга, ИТХ-ын тогтоол

Тайлант онд ИТОХ-ын төлөвлөгөөг 28149.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь “Эрдэнэс-тавантолгой” ХК-ийн 2019 оны ногдол ашгийг иргэдийн дансанд төвлөрүүлсний хувь хүний орлогын албан татварыг сумын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Сумын ИТХ-ын 2019.12.16-ний өдрийн хуралдааны 12 дугаар тогтоолоор сумын ЗДТГ, ерөнхий боловсролын сургуулийн өөрийн орлогыг тус бүр 1000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба сумын ИТХ-ын 2020.09.25-ний өдрийн хуралдааны 06 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн өөрийн орлогоор төлөвлөсөн 1000.0 мянган төгрөгийг хассан ба өөрийн орлогоор сумын ЗДТГ-т төлөвлөсөн 1000.0 мянган төгрөгийг бүрэн оруулсан байна.

Дээрх тогтоолоор сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн орлогоор тайлант онд 100000.0 мянган төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 12937.5 мянган төгрөгийг оруулсан байгааг цаашид анхаарч сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтөд анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 3283954.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3066883.8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2936523.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 130360.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 7 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байхад сумын Эрүүл мэндийн төв төсвийн төслийг хүргүүлээгүй ба аймгийн ИТХТ-ын 2019.11.29-ний өдрийн 11/09 дүгээр тогтоолоор анх 3427886.0 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	88,462.30	80710.9	-7,751.40
Засаг даргын Тамгын газар	458,341.90	400139	-58,202.90
Сургууль	1,174,925.89	1,363,715.4	188,789.52
Цэцэрлэг	475,305.35	512502.7	37,197.36
ЭМТ		539625	539,625.00
Соёлын төв	165,787.00	122950.6	-42,836.40
Бага сургууль	174,477.34	123316.1	-51,161.24
Бага цэцэрлэг	75,090.22	54745.6	-20,344.62
Сум хөгжүүлэх сан		100000	100,000.00
Орон нутгийн хөгжлийн сан		130180.7	130,180.70
Нийт дүн	2,612,389.99	3,427,886.00	815,496.01

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.16-ний өдрийн 16 дугаар тогтоолоор анх

баталсан 3427886.0 мянган төгрөгийг сумын ИТХ-ын хуралдааны 2020.09.25-ний өдрийн 12 дугаар тогтоолоор 69104.5 мянган төгрөгөөр бууруулсан ба ЕБС, Цэцэрлэгийн төсвийг аймгийн Засаг даргын 2020.10.27-ний өдрийн А/770 дугаар захирамжаар 32533.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 107360.8 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 3283954.0 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 2016962.7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 37170.8 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 103206.5 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 888614.0 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 99600.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 101000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 37400.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 20653.9 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 10338.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч, оны эцэст зардлын хэмнэлтээс 32475.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 37651.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 12. Байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улсын төсөвт төвлөрүүлсэн	ОН-ын төсөвт төвлөрүүлсэн
Засаг даргын Тамгын газар	415,209.00	396,194.93	19,014.07	95.4		25240.3
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	83,184.00	81,994.24	1,189.76	98.6		310.8
Ерөнхий боловсролын сургууль	1,292,534.90	1,232,328.73	60,206.17	95.3	34264.8	
Цэцэрлэг	425,314.50	414,035.59	11,278.91	97.3	2269.5	4552.3
ЭМТ	535,025.00	518,469.16	16,555.84	96.9		
Соёлын төв	118,950.60	115,304.03	3,646.57	96.9		2371.9
Бага сургууль	124,289.00	122,302.22	1,986.78	98.4	671.2	
Бага цэцэрлэг	56,340.60	55,894.31	446.29	99.2	446.3	
Орон нутгийн хөгжлийн сан	133,106.40	130,360.66	2,745.74	97.9		
Сум хөгжүүлэх сан	100,000.00	-	100,000.00	0.0		
Нийт дүн	3,283,954.00	3,066,883.86	217,070.14	93.4	37,651.80	32,475.30

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Бууцагаан сумын байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3066883.8 мянган төгрөг буюу 93.4 хувьтай байгаа нь Сум хөгжүүлэх сангийн төлөвлөсөн эргэн төлөлтийг оруулаагүй, ОНХС-ийн санхүүжилт болон эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг дутуу авсан, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 22924.7 мянга, байр ашиглалттай холбоотой зардлыг 46471.2 мянга, нормативт зардлыг 17313.8 мянган төгрөгөөр хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,283,954,000.00	3,066,883,859.58
70105 ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага	83,184,000.00	81,994,242.67
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	66,453,200.00	65,263,443.03
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	900,000.00	900,000.00
80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	15,830,800.00	15,830,799.64
82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийл		
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	415,209,000.00	396,194,932.27
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	270,095,700.00	253,138,577.02
80106 Баг, хорооны ҮАЗардал	78,730,700.00	76,930,935.25
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	29,382,600.00	29,355,745.00
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	29,000,000.00	28,770,300.00
82212 Хур хог хаягдал, орчны бохирдол	8,000,000.00	7,999,375.00
83201 Ангилалдаагүй бусад зориулалт,		
70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	133,106,400.00	130,360,658.00
80904 Нийгмийн зориулалттай барилга	133,106,400.00	130,360,658.00
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	535,025,000.00	518,469,157.12
80109 ТЗШБ-ын тогтмол зардал	76,298,400.00	70,081,497.72

**Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

80302 Нэг иргэнд ногдох нормативаар	38,375,100.00	38,375,100.00
81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлч	420,351,500.00	410,012,559.40
71702 Соёл урлаг	118,950,600.00	115,304,026.00
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	112,907,700.00	109,320,826.00
80214 Уран бүтээл хийх	1,259,700.00	1,200,000.00
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	4,783,200.00	4,783,200.00
71801 Сургуулийн өмнөх боловсрол	481,655,100.00	469,929,892.52
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ		
80109 ТЗШБ-ын тогтмол зардал	49,540,300.00	42,644,923.52
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	195,800.00	195,800.00
81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	31,058,200.00	31,056,939.00
81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	979,900.00	979,916.00
81834 Боловсролын стандарт, сургалт	346,849,500.00	342,487,157.74
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	53,031,400.00	52,565,156.26
71802 Ерөнхий боловсрол	1,407,234,400.00	1,345,376,448.00
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	4,806,600.00	4,773,572.00
80109 ТЗШБ-ын тогтмол зардал	251,417,800.00	224,160,800.00
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	13,145,200.00	13,145,200.00
81801 үдийн цай хөтөлбөр	26,882,400.00	16,065,400.00
81806 Дотуур байрны үйлчилгээ	156,731,500.00	138,594,069.00
81834 Боловсролын стандарт, сургалт	703,380,500.00	700,261,745.00
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	250,870,400.00	248,375,662.00
71806 Насан туршийн болон албан бус боловсрол	9,589,500.00	9,254,503.00
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	9,589,500.00	9,254,503.00
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	100,000,000.00	
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	100,000,000.00	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 40347.9 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт өгснөөс бараа үйлчилгээний зардалд 27789.4 мянган төгрөг зарцуулж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад 12048.5 мянган төгрөгийг олгож, сумын ЗДТГ санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийн 510.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 13. Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлага, төвлөрүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	Бага сургууль	Бага цэцэрлэг	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	70,940.40	33,150.90	5,562.20	12,809.20	14,085.80	5,067.20	141,615.70
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,797.60	33,150.90	5,562.20	12,699.80	14085.8	5,067.20	114,363.50
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27142.8			109.4			27,252.20
НИЙТ ЗАРЛАГА	64,450.30	7,491.50	5,562.20	12,699.80	0.00	5,067.20	95,271.00
Бараа, ажил үйлчилгээний зардал	64,450.30						64,450.30
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж							0.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		7491.5	5562.2	12699.8		5,067.20	30,820.70
Төсөвт төвлөрүүлсэн	6,490.10	25,659.40	0.00	109.40	14,085.80	0.00	46,344.70

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 134 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 14. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	14	14	14	0	
2	Хагас жил	3	3	3	0	
3	Улирал бүр	2	8	8	0	
4	Сар бүр	5	60	55	5	10 сарын мэдээллүүд хоцорсон
5	Тухай бүр	5	60	54	6	10 сарын мэдээллүүд хоцорсон
Нийт		29	145	134	11	

Эх сурвалж. Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, менежментийн захидлаар 2 зөвлөмж өгснөөс “Харьяа төсвийн байгууллагуудын төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, алдаа зөрчлийн давтан гаргуулахгүй байж, ТТЗ-ийн зүгээс төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулж холбогдох албан тушаалтнуудын ажлыг дүгнэн, хариуцлага тооцож ажиллах” зөвлөмж хэрэгжээгүй, алдаа давтагдан гарч байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Бууцагаан сумын Засаг даргын үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудитлагдсан тайлангаас 954929.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн зөрчлийг аудитын явцад залруулсан ба цаашид Засаг даргын нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдлийг үнэн зөв тайлагнаж, төрийн аудитын байгууллагад үнэн зөв, бүрэн илэрхийлсэн санхүүгийн тайланг ирүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний, эцсийн үлдэгдлийг аудитлагдсан санхүүгийн тайлантай тулган шалгахад нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайлангаар нэгтгээгүй, Э-тайланд орлого, зардлыг бөөн дүнгээр оруулсан, дансны ангилал зөрүүтэй оруулсан зэргээс шалтгаалж, аудитын явцад 357992.3 мянган төгрөгийн алдаа илэрснээс санхүүгийн байдлын тайланд 134066.6 мянга, үр дүнгийн тайланд 61979.2 мянга, мөнгөн гүйлгээний тайланд 81599.0 мянга, төсвийн гүйцэтгэлийн тайланд 42569.4 мянга, нэмэлт санхүүжилтийн тайланд 37778.1 мянган төгрөгийн алдааг залруулав.

№	Байгууллагын нэр	Санхүүгийн байдлын тайлан	Үр дүнгийн тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Нэмэлт санхүүжилтийн тайлан	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	97047.4	71.9	13,452.6	406.7	6,490.1	117,468.7
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1590	56.0				1,646.0
3	Ерөнхий боловсролын сургууль	2110		9,211.0	247.4	25,659.4	37,227.8
4	Эрүүл мэндийн төв	33019.2	7,500.0	14,254.1		66.4	54,839.7
5	Цэцэрлэг	150	853.8	24,906.7	264.7	5,562.2	31,737.4
6	Соёлын төв				255.0		255.0

**Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

7	Бага сургууль	150	5,067.2	19,324.8		24,542.0
8	Бага цэцэрлэг		48430.3	449.8	184.6	49,064.7
9	Сум хөгжүүлэх сан				41,211.0	41,211.0
	Дүн	134,066.6	61,979.2	81,599.0	42,569.4	37,778.1
						357,992.3

Дээрх алдааны дийлэнх хувь нь өмнөх оны орлого, зардлыг зөрүүтэй оруулсан, зардлын ангиллыг буруу илэрхийлсэн байснаас гадна төсвийн гүйцэтгэлийн тайланд байгууллагын ажиллагсдын болон сурагчдын тоог аудитын тайлангаас зөрүүтэй оруулсан алдаа гарсныг аудитын явцад э-тайлангийн тоогоор залруулав.

Төвлөрүүлэн захирагчид 391774.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллага аудитад хамрагдаж, сумын ИТХ-д итгэл үзүүлсэн байна.

№	Байгууллагын нэр	Аудит хийсэн байгууллагын нэр	Дүгнэлтийн хэлбэр
1	Засаг даргын Тамгын газар	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Хязгаарлалттай
2	Ерөнхий боловсролын сургууль		Зөрчилгүй
3	Эрүүл мэндийн төв	"Баян ташаагийн эх" ХХК	Зөрчилгүй
4	Цэцэрлэг		Зөрчилгүй
5	Иргэдийн төлөөлөгчийн хурал	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Итгэл үзүүлсэн
6	Соёлын төв		Түүвэрт хамрагдсан
7	Орон нутгийн хөгжлийн сан		Түүвэрт хамрагдсан
8	Сум хөгжүүлэх сан		Түүвэрт хамрагдсан
9	Бага сургууль		Түүвэрт хамрагдсан
10	Бага цэцэрлэг		Түүвэрт хамрагдсан

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн, өмнөх оны зөвлөмж, албан шаардлагыг бүрэн биелүүлээгүй, кассын тайлан, бараа материалын тайланг холбогдох журам, стандартын бэлтгэж гаргаагүйн улмаас сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 5 төсвийн байгууллага, ОНХС-д нийт 499702.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 293084.6 мянган төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулж, 2232.5 төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 175781.3 мянган төгрөгийн 8 зөрчилд албан шаардлага өгч, 28604.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг төсөв захирагч нарт хүргүүлжээ.

Үзүүлэлт	ЗДТГ	Эрүүл мэндийн төв	Цэцэрлэг	ОНХС	Ерөнхий боловсролын сургууль	Соёлын төв	Дүн
Төлбөрийн акт	тоо	3			1		4
	дүн	2079.5			153		2232.5
Албан шаардлага	тоо	6		1		1	8
	дүн	116490		58282.8		1008.7	175781.3
Зөвлөмж	тоо	2	2	3	2		9
	дүн	1620.3	0	17098.7	9885		28604.0
Залруулга	тоо	0	1	1	1	1	4
	дүн	0	7500	130360.6	154,969.0	255.0	293,084.6
Нийт алдаа зөрчил	тоо	11	3	2	4	2	25.0
	дүн	120189.6	7500	17098.7	188643.4	165,007.0	1,263.7
							499,702.4

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар Э-тайлангийн эхний үлдэгдэл нь санхүүгийн тайлан гаргаж байгаа Acolous программын эхний үлдэгдэлтэй тохирч байгаа эсэхийг тулган баталгаажуулсан эсэхийг шалгах шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.1.1. **Илрүүлэлт:** Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн орлого, зарлагын төрлийг санхүүгийн тайлангаас 357992.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.1.2. **Эрсдэл:** Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

3.1.3 **Өгсөн зөвлөмж:** Сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад тавих санхүүгийн албаны даргын хяналтыг сайжруулах.

3.1.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

3.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.2.1. **Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 9 зээлдэгч 28907.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлогыг төлөөгүй хугацаа хэтрүүлж, оны эцэст хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.7 дахь Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” заалтыг зөрчсөн байна.

3.2.2 **Эрсдэл:** Сангийн хөрөнгөөс олгосон зээл гэрээнд заасан хугацаанд төлөгдөхгүй сан хохирох, дараагийн зээлдэгч сангаас зээл авах боломжгүй болох.

3.2.3 **Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл авч хугацаандаа төлөөгүй 9 зээлдэгчийн 28907.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүг 2021 оны 06 дугаар сарын 25-ны дотор төлүүлэх арга хэмжээ авч, заасан хугацаанд төлөөгүй иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

3.3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.2.2 **Илрүүлэлт:** Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 134 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

3.2.2 **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.


3.2.3 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн: АХЛАХ АУДИТОР		Б.ДОЛЖМАА 2021.03.25
Анхан шатанд хянасан: АУДИТЫН МЕНЕЖЕР		А.ЦЭЭНЯМ 2021.03.25
Хоёр дахь шатанд хянасан: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Б.МӨНХБАТ 2021.03.25



5. Хавсралт 1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
2021.03.25			БНА-2021/16/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Бууцагаан сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан					
1	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагын төрлийг санхүүгийн тайлангаас 357992.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.	357992.3	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Лхагвадорж, З.Саран
2	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагын төрлийг санхүүгийн тайлангаас 4875.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.	4875.0	Санхүүгийн тайланд залруулсан.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Лхагвадорж, З.Саран
3	Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 9 зээлдэгч 28907.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлогыг төлөөгүй хугацаа хэтрүүлж, оны эцэст хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.	28907.1	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Лхагвадорж, З.Саран
4	Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны хуудаст 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Лхагвадорж, З.Саран
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангийн алдааны дүн		391774.4			
Харьяа төсвийн байгууллагуудын дүн					
Ерөнхий боловсролын сургууль					
1	Сургуулийн төсөвт оны эцэст зохицуулалт хийлгэж "Дэвжих болор" ХХК-аас сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9885.0 мянган төгрөгийг шилжүүлж авлага үүсгэж Төсвийн тухай хуулийн 6.4 дэх заалтыг зөрчсөн байна.	9885.0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Д.Уранчимэг, Д.Баярмаа
2	Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас захирлын 2020.12.24-ний өдрийн А/35 дугаар тушаалаар түлшний хөнгөлөлт олгохдоо захирал Д.Уранчимэг өөртөө тушаал гаргаж 153,0 мянган төгрөг авсан байна.	153.0	Төлбөрийн акт тогтоосон.	Дарга, нягтлан бодогч	Д.Уранчимэг, Д.Баярмаа

**Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

3	Оны эхэнд 2284232.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан тайлант оны эцэст 2129263.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь 2015 онд акталсан хичээлийн 2 байр болон тавилга хэрэгслийн дахин үнэлгээний 143007.5 мянга, 2018 онд акталсан тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжийн 1030.4 мянга, 2019 онд акталсан 11 жилийн сургуулийн хичээлийн байрны уурын зуух болон тоног төхөөрөмжийн дахин үнэлгээний 10931.1 мянга нийт 154969.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг данснаас хасаагүй байна.	154969.0	Санхүүгийн тайланд залруулсан.	Дарга, нягтлан бодогч	Д.Уранчимэг Д.Баярмаа
4	Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 142 мэдээллийг бүрэн байршуулсан, Үүнээс хугацаа хоцорсон 6 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл, байршуулаагүй 1 мэдээлэл байна	0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Д.Уранчимэг Д.Баярмаа
ДҮН		165007.0			
Засаг даргын Тамгын газар					
5	Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангиас 71050.0 мянган төгрөгийн өвс олгож, 23795.0 мянган төгрөгийн өвсний үнийг төлүүлж, 47255.0 мянган төгрөгийн авлагатай тооцоог гаргаж өгсөн байхад сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд өвстэй холбоотой өглөг, авлага байхгүй байна.	47255.0	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
6	"Элит хөшиг" ХХК-тай 2020.11.10-ны өдөр гэрээ байгуулж, нэг бүр нь 2500.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг авто зогсоолын автомат хаалт авсан байхад үндсэн хөрөнгөд 5000.0 мянган төгрөгийн үнээр 1 ширхгээр бүртгэсэн.	5000.0	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
7	Сумын Засаг даргын захирамжаар олгосон урамшууллаас 100.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй, 660.0 мянган төгрөгийг иргэдээс аваагүй атлаа тайланд авлагаар тусгаагүй.	760.0	Төлбөрийн акт тогтоосон.	Дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
8	Тайлант хугацаанд авсан 174.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй, "Цэнгэлийн зүг" ХХК-аас авсан 1200.0 мянган төгрөгийн үнэ бүхий ус утаа мананцаруулагч багажийг бараа материалд бүртгэсэн.	1374.0	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
9	Сумын Засаг даргад 1243.2 мянган төгрөгийн тэтгэмжийг цалинтай давхардуулан олгосон.	1243.2	Төлбөрийн акт тогтоосон.	Дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
10	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, нярав кассын тайлан гаргаагүй, бараа материалын тайлан зөрүүтэй гаргасан.	0	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
11	Тайлант онд ЗДТГ-ын байгууллагын нягтлан бодогч 3 удаа солигдсонтой холбоотой 32910.8 мянган төгрөгийн гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, санхүүгийн баримтад байхгүй байна.	32910.8	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
12	Төсвийн хөрөнгөөс 76.3 мянган төгрөгөөр архи, бохь худалдан авсан.	76.3	Төлбөрийн акт тогтоосон.	Дарга, нягтлан бодогч	
13	Шилэн дансанд байршуулах 130 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 97504.2 мянган төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
14	Санхүүгийн тайланд бүртгэлтэй өмнөх оны 553.8 мянган төгрөгийн авлага, 1066.5	1620.3	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа

**Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	мянган төгрөгийн өглөгийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.				
15	Тээврийн хэрэгслийн гэрчилгээг аудитаар тулган шалгахад 19990.0 мянган төгрөгийн үнэ бүхий 59-49 БНХ улсын бүртгэлийн дугаартай УАЗ-390942-018 маркын ачааны автомашины гэрчилгээ иргэн С.Тунгалагийн нэр дээр бүртгэлтэй, багийн дарга нар ашиглаж байгаа 9960.0 мянган төгрөгийн 6 ширхэг мотоцикл тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй байна.	29950.0	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
	ДҮН	120189.6			
Орон нутгийн хөгжлийн сан					
16	Сумын ОНХС-ийн хөрөнгөөс 2021.12.22-ний өдөр Таванчимэг хоршоонд 16450.0 мянга, 2021.12.23-нд Чорьжбүрд ХХК-д 41832.8 мянган төгрөгийг шилжүүлж, гэрээнд заасан ажлыг бүрэн хийж гүйцэтгээгүй байна.	58282.8	Албан шаардлага өгсөн.	Сумын Засаг дарга, нягтлан бодогч	Д.Лхагвадорж, М.Дуламрагчаа
17	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг зөв тайлагнаагүй байна.	130360.6	Санхүүгийн тайланд залруулсан.	Сумын Засаг дарга, нягтлан бодогч	Д.Лхагвадорж, М.Дуламрагчаа
	ДҮН	188643.4			
Соёлын төв					
18	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг төсөв баталсан тогтоолтой тулгахад мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд батлагдсан 255.0 мянган төгрөгийг цалингийн зардалд тайлагнасан байна.	255.0	Санхүүгийн тайланд залруулсан.	Дарга, нягтлан бодогч	М.Мөнхтоого, М.Дуламрагчаа
19	Тус байгууллага өмнөх онд 1008.7 мянган төгрөгийн авлагатай гарсныг тайлант онд барагдуулж ажиллаагүй байна.	1008.7	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	М.Мөнхтоого, М.Дуламрагчаа
	ДҮН	1263.7			
Цэцэрлэг					
20	Шилэн дансны тухай хуулийн хүрээнд байршуулах мэдээллээс тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, батлагдсан төсөв, хөрөнгө зарцуулах шийдвэр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг 4 төрлийн мэдээллийг байршуулснаас хойш дахин засварласнаас хугацаа хоцроосон байна.	0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Д.Гэрлээ Д.Мөнхтуяа
21	Гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ Тулга Техник ХХК-д шилжүүлээд авлагаар бүртгэсэн.	1520.0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Д.Гэрлээ Д.Мөнхтуяа
22	Санхүүгийн тайлангийн авлага өмнөх оноос 17098,7 мянган, өглөг 148,5 мянган төгрөгөөр тус нэмэгдсэн.	15578.7	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Д.Гэрлээ Д.Мөнхтуяа
	ДҮН	17098.7			
Эрүүл мэндийн төв					
23	Тусгай зориулалттай бараа материал дансанд 800,0 мянган төгрөгийн шатахуун, бусад хангамжийн бараа материал дансанд 5644,8 мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгсэл бүртгэгдсэн байна.	0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Э.Гантулга Д.Мөнхтуяа
24	Сургалтын зардлын авлагын 7500,0 мянган төгрөгийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлж 2020 оны 7 дугаар сарын 02-ны өдөр Аймгийн төрийн сангийн татварын орлогын 100030000952 тоот дансанд төвлөрүүлснийг санхүүгийн тайланд залруулж бүртгээгүй байна.	7500.0	Санхүүгийн тайланд залруулсан.	Дарга, нягтлан бодогч	Э.Гантулга Д.Мөнхтуяа

**Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

25	Шилэн дансны тухай хуулийн хүрээнд байршуулах мэдээллээс нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны тайлан, хөрөнгө зарцуулах шийдвэр гэсэн 3 мэдээллүүдийг хугацаа хоцроож байршуулсан.	0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Э.Гантулга Д.Мөнхтуяа
	ДҮН	7500.0			
	Төсвийн шууд захирагчийн тайлангийн алдааны дүн	499702.4			

---oOo---